

ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ/ 12-Р АНГИ/

80 МИНУТ

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 1 оноотой.


1. Эрчим хүчний эх үүсвэрүүдээс сэргээгдэх эх үүсвэрийг тодорхойлно уу /1 оноо/
А. Газрын тос В. Нүүрс С. Цөмийн эрчим хүч Д. Салхины эрчим хүч
2. Газрын тос экспортлогч ОПЕК-ийн орнуудаас олборлолтоороо тэргүүлэгч орныг тодорхойлоорой /1 оноо/
А. Кувейт В. Венесуэл С. Саудын Араб Д. АНЭУ
3. Эдгээр орнуудаас эдийн засаг нь анхдагч салбараар голлон төрөлжсөн орон аль нь вэ? /1 оноо/

Улс	Арабын нэгдсэн Эмират	Монгол	Япон	Бразил
Эдийн засгийн төрөлжилт	Газрын тос, аялал жуулчлал	Нүүрс, зэс	Робот, суудлын машин	Кофе, тээврийн хэрэгсэл

4. Хятад, АНУ, Энэтхэг, Пакистан, Узбекистан улсууд нь дэлхийн зах зээлд ямар төрлийн бүтээгдэхүүнээр төрөлжин оролцдог вэ? /1 оноо/
А. Цай В. Кофе С. Хөвөн Д. Цагаан будаа
5. Энэтхэг, Бразил, АНУ, Хятад, Аргентин зэрэг орнууд малын ямар төрлөөр дэлхийд тэргүүлэгч орнууд вэ? /1 оноо/
А. Хонь В. Ямаа С. Адуу Д. Үхэр
6. Хийн болон шингэн түлшийг өндөр даралтын нөлөөгөөр тасралтгүй тээвэрлэдэг, эдийн засгийн үр ашигтай, зардал багатай, аюулгүй байдлыг сайн хангасан тээврийн төрлийг сонгоно уу. /1 оноо/
А. Агаарын тээвэр В. Дамжуулах хоолойн тээвэр
С. Усан замын тээвэр Д. Төмөр замын тээвэр
7. Дараах олон улсын байгууллагуудаас цэрэг, энх тайвны зорилготой байгууллага аль нь вэ? /1 оноо/
А. Европын холбоо В. Дэлхийн банк С. НАТО Д. ОПЕК
8. Агаарт хүхэрлэг хий их хуримтлагдсанаас болж Европ, Хойд Америкт хүчлийн бороо их тохиолдох бөгөөд үүнээс үүдэх сөрөг үр дагаварт хамаарахгүй хувилбарыг олоорой. /1 оноо/
А. Гол нуурын амьд организм устгах В. ургац алдах, ой устах
С. Хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх Д. технологийн дэвшил удаашрах
9. Арал нь дундад Азийн давстай урсгалгүй тэнгис бөгөөд 1960 оноос эхлэн тус тэнгист цутгах Амударья, Сырдарья голуудыг хөвөнгийн болон цагаан будааны тариалангийн усалгаанд ашиглах болсон нь ямар үр дагаврыг авчирсан бэ? /1 оноо/
А. усны түвшин багассан В. усны давсжилт нэмэгдэж загасны төрөл зүйл буурсан
С. цөлжилтөнд хүчтэй өртсөн Д. дээрх бүгд
10. Хятад, Хойд ба Өмнөд Солонгос, Монгол, Япон улсууд аль бүс нутагт багтах вэ? /1 оноо/
А. Зүүн Ази В. Зүүн Өмнөд Ази С. Өмнөд Ази Д. Баруун Өмнөд Ази


11. Дэлхийн улс төр, эдийн засгийн харилцаанд голлох байр суурийг эзлэгч, компьютер, сансар судлал, зэвсэг, машин зэргийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч бүс нутгийг сонгоно уу? /1 оноо/
 А. Европын бүс В. Зүүн Ази С. Латин Америк Д. Хойд Америк
12. Персийн булангийн орнууд газрын тосоор баялаг, орлого ихтэй ч хүний хөгжлийн индексээр доогуур ордгийн шалтгаанд хамаарахгүйг олоорой. /1 оноо/
 А. бичиг үсэгт тайлагдалтын түвшин доогуур В. байгалийн баялаг нөөцтэй
 С. охидын боловсролыг дэмждэггүй Д. шашны нөлөө ихтэй
13. 1980 оноос дэлхийн улс орнуудыг аж үйлдвэржсэн байдал болон нэг хүнд ногдох орлогод тулгуурласан “Хойд” ба “Өмнөд” гэсэн энгийн ангиллыг хэрэглэх болжээ. Доорх орнуудаас “Өмнөд” оронд багтах улсыг сонгоорой. /1 оноо/
 А. АНУ В. Европ С. ОХУ Д. Нигери
14. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй технологийг ол
 А. Голын эхэнд уул уурхайн олборлолт хийх
 В. Салхин сэнсээр энерги үйлдвэрлэх
 С. Хонины аж ахуйгаар дагнах
 Д. Хот орчимд малын арьс боловсруулах
15. программ бол тандан судалгааны зураглал дээр суурилсан дэлхийн тухай маш том интернэт газарзүйн мэдээллийн систем юм. /1 оноо/
 А. Googleearth В. Газарзүйн мэдээллийн систем
 С. Зайнаас тандан судлал Д. Газарзүйн тусгаг

16. Дараах зурагт зурагзүйн дүрслэлийн аль аргыг ашигласан байна вэ? /1 оноо/



- А. Ижил шугам
 В. Өнгөт дэвсгэр
 С. Картодиаграмм
 Д. Хөдөлгөөнт шугам

17. Дараах зурагт газарзүйн ямар судалгааны аргыг илэрхийлж байна вэ? /1 оноо/




- А. Газарзүйн мэдээллийн систем В. Зайнаас тандан судлал
 С. Googleearth программ Д. Газарзүйн зураг

18. Дараах зургийг ажиглан ямар тусгаагаар зурагласан болохыг тодорхойлоорой. /1 оноо/




- A. Меркатор В. Синусиод С. Гүүд D. Азимут

19. 6-р сарын 22-ны “Нар буцах өдөр” үд дундын нар ямар өргөрөг дээр эгц тусах вэ? /1 оноо/



- A. Матрын зам
B. Мэлхийн зам
C. Экватор
D. Хойд туйл


20. Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийн үзүүлэлтэд асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. /1



- A. Хөдөлмөрийн нөөц В. Боловсролын түвшин С. Ажиллах хүч
D. Тогтвортой хөгжил
21. Нарны аймгийн гаригуудыг ерөнхий шинжээр нь зөв ангилсныг сонго /1 оноо/
A. Дэлхий төст ба Буд төст В. Дэлхий төст ба Бархасбадь төст
C. Дэлхий төст ба Ангараг төст D. Бархасбадь төст ба Тэнгэрийн ван төст
22. 1 одон орны нэгж зай нь 150 сая км-тэй тэнцэнэ. Нарнаас Буд гараг хүртэл 58 сая км бол одон орны нэгжээр илэрхийлсэн зөв хариуг ол. /1 оноо/
A. 0,38 В. 2,58 С. 92 D. 208
23. Нар, сар, дэлхийн харилцан байрлал өөрчлөгддөгөөс сарны харагдах хэлбэр янз бүр байдаг. Тэргэл сар гарах үеийн байрлалыг олоорой. /1 оноо/
A. Сар-дэлхий-нар В. Нар-сар-дэлхий
C. Дэлхий-нар-сар D. Сар-дэлхий-сар
24. Ардчилалын индекс хамгийн бага улсыг сонгоорой. /1 оноо/
A. Конго В. Хойд Солонгос С. Хятад D. Вьетнам
25. Дэлхийн хамгийн том гол мөрний ай савыг сонго. /1 оноо/
A. Амазон В. Нил С. Ганга D. Обь

26. хонхор газар хуримтлагдан тогтсон, далай тэнгистэй холбогдоогүй, экологийн өвөрмөц орчныг бүрдүүлдэг хуурай газрын усны нэг төрөл юм. /1 оноо/
 А. Цэвдэг В. Мөсөн гол С. Нуур D. Газар доорх ус
27. Далайн усны давжилт тропикийн их даралтын бүсэд хамгийн их байдаг шалтгааныг тодорхойлно уу. /1 оноо/
 А. Хур тунадас их В. Хур тунадас бага
 С. Ууршилт бага D. Далайн урсгалын солилцоо их
28. Өгүүлбэрийг нөхөөрэй. Уур амьсгал ба цаг агаарын үндсэн ялгаа нь юм. /1 оноо/
 А. Агаарын температур В. Агаарын даралт С. Агаарын чийгшил D. Цаг хугацаа
29. Улаанбаатарт агаарын даралт 1029гПа байсан ба агаарын даралт огцом унаж байна. Цаг агаарын ямар үзэгдэл болох вэ? /1 оноо/
 А. Тэнгэр цэлмэж, агаарын хэм буурна В. Цаг агаар тогтвортой байна
 С. Гэнэтийн хүчтэй шуурга болно D. Цаг агаар сайжирна
30. Агаар мандлын үе давхаргуудаас дээшлэх тусам температур нь нэмэгддэг үе давхаргуудыг сонгоно уу. /1 оноо/
 А. Тропосфер, стратосфер В. Тропосфер, мезосфер
 С. Стратосфер, термосфер D. Мезосфер, стратосфер
31. Шинэхэн цас орсны дараа нүд гялбаад, зарим хүмүүс бараан шил зүүдэг нь цацрагийн ямар шинжтэй холбоотой вэ? /1 оноо/
 А. Ойсон цацраг В. Сарнисан цацраг
 С. Шулуун цацраг D. Сарнисан цацраг
32. Өнөөдөр дэлхийн 10 хүн тутмын 5 нь хотод амьдарч байна. Цаашид энэ хотжилтын үйл явц нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын төвлөрөл улам нэмэгдэх үед хотыг тогтвортой бөгөөд хүний амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж хөгжүүлэхэд аль нь хотжилтоос үүдэх асуудлыг багасгахад нөлөөлж ЧАДАХГҮЙ вэ? /1 оноо/
 А. Экологийн мөр хамгийн бага, хамгийн бага бохирдол гаргах
 В. Хог хаягдлыг эрчим хүч болгон хувиргах, дахин ашиглах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах
 С. Ногоон байгууламжийг барилга, орон зайд давхар шийдлээр төлөвлөх
 D. Хотын иргэн бүрийн хувийн унааг дэмжих
33. Ямар орнуудад хүн амын ердийн өсөлт ($11-10=1$) байх вэ? /1 оноо/
 А. Өндөр хөгжилтэй орнуудад В. Хөгжиж буй орнуудад
 С. Буурай хөгжилтэй орнуудад D. Хэт олон хүн амтай орнуудад
34. $P_n = P_0(1 + (R/100)T)$ гэсэн нь юуг олдог томъёо вэ? /1 оноо/
 А. хүн амын тоо 2 дахин нэмэгдэх хугацаа В. хүн амын өсөлтийн хэтийн төлөв
 С. хүн амын нөхөн үйлвэрлэл D. хүн амын шилжилт
35. Хөгжингүй орнуудын хүн ам хотоос хөдөө рүү шилжихэд нөлөөлөх татагч хүчин зүйлд аль нь хамаарах вэ? /1 оноо/
 А. дарамттай амьдралын хэв маяг В. бохирдол багатай тайван орчин
 С. зав зайгүй байдал, замын түгжрэл D. чимээ шуугиантай орчин
36. Алтай язгуурын хэлний тархалтыг зөв тодорхойлсон хариуг олоорой. /1 оноо/
 А. Европ ба Хойд Америк В. Төв болон Зүүн Ази
 С. Өмнөд Америк D. Өмнөд Африк
37. “Хүн амын өсөлтийн график “J” хэлбэрээр дүрслэгддэг” гэсэн тодорхойлолтоос өсөлтийн үйл явц ямар байгаа гэсэн дүгнэлт хийж болох вэ? /1 оноо/
 А. Хүн амын тоо нь бууралт, өсөлттэй хэлбэлзэж байсан
 В. Хүн амын өсөлт эрс хурдацтай өсөх болсон
 С. Хүн амын тоо буурч байсан
 D. Хүн амын тоо тогтмол, өсөлт зогсонги болсон


38. Япон улсын хүн амын өөрчлөлтийг хүн амын суваргаар харуулжээ. Зургийг ашиглан зөв хариуг олоорой. /1 оноо/



- A. 2050 онд 70-аас дээш насны хүн амын эзлэх хувь 2 дахин өснө
 B. 2050 онд 15-65 насны хүн ам 2 дахин буурна
 C. 2050 онд 0-15 насны хүн ам 2 дахин өснө
 D. 2050 онд 0-15 насны хүн ам 2 дахин буурна
39. Хэт цөөн хүн амтай улсын хүн амын асуудлаар баримтлах бодлого юунд чиглэсэн байх ёстой вэ? /1 оноо/
- A. Хүүхдийн болон эхэд шаардлагатай тэтгэмжийг нэмэгдүүлэх
 B. 1 айл 1 хүүхэд бодлого хэрэгжүүлэх
 C. Гэрлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтыг олшруулах
 D. Боловсрол эрүүл мэндийн үйлчилгээг өндөр төлбөртэй болго
40. Дэлхийн хамгийн гадна талын нимгэн, хатуу бүрхэвч аль нь вэ? /1 оноо/
- A. Астонесфер B. Манти C. Агаар мандал D. Чулуун мандал
41. Уур амьсгалын ямар нөхцөлд, химийн өгөршил илүү эрчимтэй явагдах вэ? /1 оноо/
- A. Хуурай ба халуун B. Халуун ба чийглэг
 C. Сэрүүн ба хуурай D. Сэрүүн ба чийглэг
42. Үелж давхраатсан тогтоцтой, эртний амьтан ургамлын үлдэгдлийн ул мөр элбэг чулуулгууд ямар гарал үүсэлтэй вэ? /1 оноо/
- A. тунамал чулуулаг B. хувирмал чулуулаг
 C. магмын чулуулаг D. галт уулын чулуулаг
43. Газар хөдлөлтийн үед ямар үйлдэл нь таныг эрсдэлд оруулах вэ? /1 оноо/
- A. Цонхоор харах, цахилгаан шатаар явах, гүүрэн доогуур орох
 B. Таазны гэрэл зэрэг унах зүйлсээс холдох
 C. Хана, булан, даацын багана зэрэг аюулгүй газар хоргодох, ширээн доогуур орох
 D. Гадаа байсан үед байшин, барилга, мод, гэрэл болон цахилгааны шонгоос холдох
44. Дэлхийн тэнхлэгээ эргэж, өдөр шөнө солигдох нь газарзүйн бүрхэвчийн ямар шинжийн жишээ болох вэ? /1 оноо/
- A. Бүс ба бүслүүрлэг шинж B. Хэмнэл, мөчлөгтэй шинж
 C. Зохицуулах шинж D. Нэгдмэл байх шинж
45. Доройтсон хөрсийг сайжруулахын тулд хийх ТОХИРОМЖГҮЙ шийдвэр аль нь вэ? /1 оноо/
- A. Навч, ургамлын үлдэгдлийг хөрсөн дээгүүр бүрхэх
 B. Хүнсний хаягдлыг цуглуулж бордоо хийх
 C. Ариутгалын бодисоор хөрсөө угаах
 D. Малын бууц, шувууны сангасаар бордох

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

1. Хоногийн хугацаанд температур ба харьцангуй чийг хэрхэн өөрчлөгдөхийг доорх графикаар харуулжээ.



1. Агаар хамгийн хуурай үе хэдээс хэдэн цагийн хооронд байна вэ? /2 оноо /
.....
2. 20°C агаарт чийглэгийн багтаамж 17.5г/м³ байдаг бөгөөд үнэмлэхүй чийг 8 г/м³ байсан бол харьцангуй чийгийг бодож олно уу. /3 оноо /
.....
.....
3. Завхан гол Отгонтэнгэр уулын өвөр д.т.д 2129 м өндөртэй хэсгээс эх авч 808 км урсаадд.т.д 1030 м өндөртэй Айраг нуурт цутгадаг. Өгөгдлийг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй.

1. Голын уналыг олоорой. /2 оноо /
.....
2. Голын хэвгийг олоорой. / м/км / / 3 оноо /
.....
.....

ХАРИУЛТЫН ХУУДАС

..... сургуулийн ангийн сурагч
 овогтой.....

Д/д	Авах оноо	Сурагчийн сонгосон хариулт	Авсан оноо
1	1		
2	1		
3	1		
4	1		
5	1		
6	1		
7	1		
8	1		
9	1		
10	1		
11	1		
12	1		
13	1		
14	1		
15	1		
16	1		
17	1		
18	1		
19	1		
20	1		
21	1		
22	1		
23	1		
24	1		
25	1		
26	1		
27	1		
28	1		
29	1		
30	1		
31	1		
32	1		
33	1		
34	1		
35	1		
36	1		
37	1		
38	1		
39	1		
40	1		
41	1		
42	1		
43	1		
44	1		
45	1		

Д/д	Авах оноо	Хариулт	Авсан оноо
1	1	2 оноо	
	2	3 оноо	
2	1	2 оноо	
	2	3 оноо	

ТҮЛХҮҮР

Д/д	Хариулт	оноо
1	d	1
2	c	1
3	b	1
4	c	1
5	d	1
6	b	1
7	c	1
8	d	1
9	d	1
10	a	1
11	d	1
12	b	1
13	d	1
14	b	1
15	a	1
16	d	1
17	b	1
18	c	1
19	b	1
20	b	1
21	b	1
22	a	1
23	a	1
24	b	1
25	b	1
26	c	1
27	b	1
28	d	1
29	c	1
30	c	1
31	a	1
32	d	1
33	a	1
34	b	1
35	b	1
36	b	1
37	b	1
38	a	1
39	a	1
40	d	1
41	b	1
42	a	1
43	a	1
44	b	1
45	c	1

Д/д		Авах оноо	Хариулт
1	1	2 оноо	14-16 цагийн хооронд цагийг бичсэн бол
	2	3 оноо	Харьцангуй чийг- 45.7%
2	1	2 оноо	Унал-1099м
	2	3 оноо	Хэвгий- 1.3м/км